



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН  
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ  
ТОГТООЛ

2023 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Намын нэр, дүрмийн өөрчлөлтийг  
улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдлийг  
буцааж, бүртгэхээс татгалзах тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, С.Батдэлгэр, М.Батсуурь, Х.Батсүрэн, Б.Батцэрэн, Н.Баярмаа, П.Золзаяа, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Д.Эрдэнэбалсүрэн, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар

Монголын либерал намын дарга Э.Оргилоос 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдөр ирүүлсэн “Монголын либерал нам 2023 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит 7 дугаар Их Хурлаар намын оноосон нэрээ “Ардчилсан монгол ялна”, намын дүрэмд оруулсан өөрчлөлтүүдийг тус тус улсын бүртгэлд бүртгүүлэх тухай” өргөдлийг шүүгч Д.Батбаатарын танилцуулснаар хянан хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Монголын либерал намын дарга Э.Оргил 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн албан бичгээр ирүүлсэн өргөдөлдөө: “Монголын либерал нам 2023 оны 02 дугаар сарын 05-ны өдөр ээлжит 7 дугаар Их хурлаа хийж, оноосон нэрээ “Ардчилсан Монгол Ялна” болгон өөрчилсөн. Мөн намын дүрэмд Монголын либерал нам гэсэн нэршлээ Ардчилсан Монгол Ялна болгон өөрчилснийг улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлтэй байна” гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаан дараах үндэслэлээр бүртгэхээс татгалзаж, өргөдлийг буцааж шийдвэрлэлээ.

Улс төрийн намын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Намын дотоод зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог намын дүрмээр зохицуулна”, 13 дугаар зүйлийн 13.1-д “Намын удирдах дээд байгууллага нь намын Их Хурал байна”, 13.2-т “дараахь асуудлыг зөвхөн намын Их Хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ:”, 13.2.1-д “намын дүрэм, мөрийн хөтөлбөрийг батлах;”, 13.2.3-т “намыг өөрчлөн байгуулах, үйл ажиллагааг нь зогсоох, намын нэрийг өөрчлөх.” гэж заасан.

Монголын либерал намын Удирдах зөвлөл 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн “Намын ээлжит 7 дугаар Их Хурлыг товлон зарлах тухай” 01/23 дугаар тогтоолоор намын ээлжит 7 дугаар Их Хурлыг 2023 оны 02 дугаар сарын 05-ны өдөр товлон зарлаж, намын Их Хурлын төлөөлөгч сонгох журам, төлөөлөгчдийн тоог баталсан, улмаар намын ээлжит 7 дугаар Их Хурал 2023 оны 02 дугаар сарын 05-

ны өдөр хуралдаж холбогдох шийдвэрийг гаргасан нь өргөдөл, түүнд хавсаргасан баримтуудаар тогтоогджээ.

Монголын либерал намын дүрмийн 3.4.6-д “Намын ээлжит Их Хурлыг хуралдах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө зарлана” гэж заасан бөгөөд Намын ээлжит 7 дугаар Их Хурлыг зарлан хуралдуулсан процесс, үйл ажиллагаа нь дүрмийн дээрх заалтад нийцээгүй, тодруулбал, 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр зарлагдаж, 2023 оны 02 дугаар сарын 05-ны өдөр хуралдсан Их Хурлаас гаргасан шийдвэрийг хуульд нийцсэн гэж үзэхгүй.

Түүнчлэн, намын Удирдах зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/23 дугаар тогтоолын 2 дахь заалтаар “Намын Их Хурлын төлөөлөгч сонгох журам, төлөөлөгчийн тоог хавсралтаар баталсан” гэх боловч шүүхэд тухайн хавсралтыг ирүүлээгүй, төлөөлөгчдийн овог, нэрсийн бүртгэл бүрэн бус байна.

Иймд Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Монголын либерал намын дарга Э.Оргилоос 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдөр ирүүлсэн “Монголын либерал нам 2023 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит 7 дугаар Их Хурлаар намын оноосон нэрээ “Ардчилсан Монгол Ялна нам” болгон, намын дүрэмд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай” өргөдлийг буцааж, бүртгэхээс татгалзах нь зүйтэй гэж үзэв.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.6, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-т заасныг тус тус баримтлан Монголын либерал намын дарга Э.Оргилын “Монголын либерал намын нэр болон дүрэмд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай” өргөдлийг буцааж, бүртгэхээс татгалзсугай.

2.Өргөдөл гаргагчаас улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 150000 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,  
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ШҮҮГЧ

Д.БАТБААТАР